



УЛС ХООРОНДЫН ШУУДАН
ИЛГЭЭМЖИЙН ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА
Б.МЯГМАР ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/317.
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26.1-д заасны дагуу тайланг хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Нягтлан бодогчдын олон улсын холбооноос баталсан Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Үндэсний аудитын газраас гаргасан Санхүүгийн аудитын гарын авлагын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, гарын авлагын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь дүн хэмжээ болон илчлэл тодруулгыг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгадаг. Түүнчлэн аудитаар удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн зарчим, хийсэн чухал тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлдэг.

Бидний хийсэн аудит санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\0223SAG22.Docx

УХА0122



**УЛС ХООРОНДЫН ШУУДАН ИЛГЭЭМЖИЙН
ГААЛИЙН ГАЗАР
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Санхүүгийн аудитын газрын
Захирал : Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын тайлан

Санхүүгийн аудитын газрын
Аудитын менежер: Я.Самбууням
Аудитор: Ж.Болормаа
Утас: 261685

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ТАБ-ын хаяг: Монгол улсын
Үндэсний аудитын газар
Байршил: Засгийн газрын IV байр
Монгол улс
Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 6

Манай вэб: www.city.audit.mn

Цахим хуудас: www.audit.mn

Эс Эм Аудит ХХК-ийн захирал
Ш.Сувдаа 99996778

Багийн ахлагч ахлах аудитор
Ш.Эрдэнэчимэг 97111708

АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
10. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
11. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
12. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
13. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
14. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
15. Зөвлөмж
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8,9,1-д заасны дагуу Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол улсын төсвийн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

“Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-ын 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт юм.

“Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар” санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 25-наас 2017 оны 2 дугаар сарын 25 –ны хооронд хийхээр төлөвлөн “Эс-Эм Аудит” ХХК-ийн аудитор Ш. Эрдэнэчимэг ахлагчтай 1 дүгээр багийнхан хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/
Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2017 оны 01 дүгээр сарын 25 өдөр “Эс Эм Аудит” ХХК-нд ирүүлсэн байна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Аудитыг Төрийн аудитын тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Монгол улсын төсвийн тухай хууль, болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу гүйцэтгэлээ.

Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж, түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын зорилго,үйл ажиллагаа:

Гадаадад ажиллаж, амьдарч байгаа монголчуудын шуудан илгээмжийг улс хоорондын илгээлтийн үйлчилгээгээр түргэн шуурхай хангах Монгол улсын хуулийн хүрээнд үйлчилгээ үзүүлэх явдал гэж байгууллагын үйл ажиллагааны зорилтыг тодорхойлсон байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна. Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагын дарга тус агентлагын шууд захирагч байна” гэж заасны дагуу Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын дарга Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны төсвийг Гаалийн ерөнхий газраас олгож байна. Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав. Аудитаар Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд нягтлан бодох бүртгэлийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын нарийвчилсан горим, сорил 18-г гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан, гаалийн ерөнхий газраас батлагдсан дансны жагсаалт заавар мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна. ОУ-ын стандарттай нийцсэн бүртгэлийн бодлоготой, нягтлан бодох бүртгэлийн программ нийцсэн байна.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн программаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Материаллаг байдал:

Төлөвлөлтийн үе шатны үед тооцоолсон материаллаг байдлын түвшинг жинхэнэ гүйцэтгэлээрх тоо хэмжээнд тулгуурлан дахин тооцож төлөвлөлтийн үед тооцоолсон материаллаг байдлын түвшин зохистой байсан эсэхийг тулган баталгаажуулав. Төлөвлөлтийн үед эхний хувилбар санхүүгийн тайлан дахь нийт хөрөнгийн 1 хувиар материаллаг байдлыг тодорхойлогдсон бөгөөд энэ нь 10,9 сая төгрөг, Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын үйл ажиллагаанд аудитын төлөвлөлтийн үе шатнаас өөрчлөлт ороогүй байна. Материаллаг байдлын хэмжээг дээрх хувь хэмжээнд тулгуурлан тооцоход гүйцэтгэлээр балансын үлдэгдэлд өөрчлөлт гараагүй байна. /ТАБ-СТА-А- 2/

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын дотоод хяналт эрсдэлийг төлөвлөлтийн үед дунд гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт төлөвлөлтийн үеийнхтэй ижил байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу салбарын яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлсэнээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийн зардлын төрөл зүйлээр хувиарлан төсвийн гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын төсвийн захирагч нь 2015 онд төсвийн урсгал зардалд 2059,9 сая төгрөгийн санхүүжилт авч, урсгал зардалд 1008,3 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 1051,6 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 18 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 25 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад

санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бусад орлого, бичиг хэрэг, тээвэр шатахуун, шуудан холбоо зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан нарийвчилсан сорилд цалин 100 хувь, мөнгөн хөрөнгийн зардлыг 100 хувь, үндсэн хөрөнгө бараа материалын орлогыг 50,0 хувь, бичиг хэргийн зардалд 42,7 хувь, эд хогшил худалдан авах зардалд 54,3 хувь хамруулан үзлээ.

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Мөнгөн гүйлгээний тайланд Байрны түрээсийн 1964,0 мянган төгрөгийн зардлыг унаа хоолны хөнгөлөлтийн зардлын дансруу ангилал хийсэн нь: “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар...-ыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь:

Зөвлөмжийг хэрэгжүүлж зөрчил дутагдлыг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн болно.

Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Аудитын явцад залруулагдаагүй алдаа гараагүй болно.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй болно.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад эд хөрөнгө, бараа материалын тооллогод ажиглалт хийгээгүй тул завсрын аудитаар горим, сорил хэрэгжүүлж ажиллах болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Улс хоорондын шуудан илгээмжийн газрын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн алдаа зөрчил илрээгүй бөгөөд удирдлагын анхааралд хандуулж 1 зөвлөмж өгсөн болно.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын удирдлагад 2015 оны санхүүгийн тайланд Үндэсний аудитын газраас хийсэн аудитаар 1 зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газрын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шудрага илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 4 хуудас, санал хуудсыг тус тус хавсаргав

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.Наранчимэг

2017 он... сар

АУДИТЫН МЕНЕЖЕР:

Я.Самбууням

2017 он... сар....

БЭЛТГЭСЭН:

“Эс-Эм Аудит” ХХК-ийн

Захирал:

Ш. Сувдаа

2017 он 02 сар 18

АУДИТОР:

Ш. Эрдэнэчимэг

2017 он 02 сар 18



**УЛС ХООРОНДЫН ШУУДАН
ИЛГЭЭМЖИЙН ГААЛИЙН ГАЗАР
2016 оны САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Санхүүгийн аудитын газрын
Захирал : Ц.Наранчимэг
Утас: 261663

Санхүүгийн аудитын газрын
Аудитын менежер: Я.Самбууням

Аудитор: Ж.Болормаа
Утас: 261663

Менежментийн Захидал

Асуудал 1

ТАБ-ын хаяг: Монгол улсын
Үндэсний аудитын газар
Байршил: Засгийн газрын IV байр
Монгол улс Чингэлтэй дүүрэг
Бага тойруу 6
Манай вэб: www.city.audit.mn

Мөнгөн хөрөнгө

Цахим хуудас: www.audit.mn

Эс Эм Аудит ХХК захирал
Ш.Сувдаа 99996778

Багийн ахлагч ахлах аудитор
Ш.Эрдэнэчимэг 97111708

Менежментийн Захидал

Төрийн аудитын тухай хуулийн 18.5,Төсвийн тухай хуулийн 8.9.8, Монгол улсын Ерөнхий Аудиторын 2016 оны 09 дүгээр сарын 01-ний А/93 дугаар тушаал,Үндэсний аудитын газрын 2016 оны 01 дүгээр сарын 12-ний өдрийн “Аудитын хуваарь хүргүүлэх тухай” 28/2016 тоот албан бичгийг үндэслэн танай байгууллагын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын шатны ажлыг гүйцэтгэлээ.

Бид танай байгууллагын нягтлан бодох бүртгэл,дотоод хяналтын тогтолцоо,хэрэгжүүлдэг горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд хянасан бөгөөд бүх сул талыг илрүүлэх боломжгүй юм.

Бид аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг байгууллагын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал ,горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг төрийн аудитын байгууллагын аудитын горимоос урган гарсан болно.Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт,дүгнэлтийг тусгаж байгаа болно.Эдгээр зөвлөмжийг та бүхний бүртгэл,тайлагнал,хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготойгоор хүргүүлж байгаа бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч,хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан “Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-ын холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ҮАГ-ийн ажиглалт

Мөнгөн гүйлгээний тайланд 210304 гэсэн кодтой Байрны түрээсийн 1964,0 мянган төгрөгийн зардлыг 210103 гэсэн кодтой унаа хоолны хөнгөлөлтийн зардлын дансруу ангилан хийсэн нь: “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”-ийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар ...-ыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах гэсэн заалтыг зөрчсөн байна.

Эрсдэл

Мөнгөн хөрөнгийн орлого, зарлагыг зөв ангилан бүртгээгүй байх

ҮАГ-ийн зөвлөмж

Стандартын дагуу эдийн засгийн ангилалыг зөв ангилан бүртгэж байх

Зөвшөөрсөн:

Зөвлөмжийг хэрэгжүүлж, зөрчил дутагдлыг давтан гаргахгүй ажиллах талаар хариу ирүүлсэн байна.

Бэлтгэсэн: Аудитор...../Ш.Эрдэнэчимэг/

2017 он 02 сар 08 өдөр

Менежерийн санал.....

2017 он 02 сар 08 өдөр.

.....
Анхан шатанд хянасан:

Чанарын менежер..... / О. Чулуунбаатар/ 2017 он 02 сар 08 өдөр

“Эс Эм Аудит “ХХК захирал /Ш. Сувдаа/ 2017 он 02 сар 08 өдөр

Хоёр дахь шатанд хянасан:

Үндэсний Аудитын газрын

Аудитор

..... / Ж.Болормаа / 2017 он 02 сар 08 өдөр

УЛС ХООРОНДЫН ШУУДАН ИЛГЭЭМЖИЙН
ГААЛИЙН ГАЗРЫН ДАРГА Б.МЯГМАР ТАНАА

Аудитын гэрчилгээ

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1, 18.5 дахь заалтуудыг үндэслэн “Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

“Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-ын тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэл /УСНББОУС/ түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь үндэсний төвийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

Санал дүгнэлтийн үндэслэл

Санхүүгийн аудитын газар аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар “Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-ын 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн болно.

Зөрчилгүй санал дүгнэлт

“Улс хоорондын шуудан илгээмжийн гаалийн газар”-ын 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Ц.НАРАНЧИМЭГ

Аудитлагдсан Санхүү байдлын тайлан

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	24,089,200.23	18,677,067.51
35	БАРАА МАТЕРИАЛ	24,089,200.23	18,677,067.51
35300	Бэлэн бүтээгдэхүүн	0.00	197,500.00
35400	Хангамжийн материал	20,739,200.23	15,129,567.51
35410	Бичиг хэргийн материал	82,350.00	517,350.00
35420	Аж ахуйн материал	10,714,467.03	5,918,047.03
35470	Бусад хангамжийн материал	9,942,383.20	8,694,170.48
35600	Мал амьтад	3,350,000.00	3,350,000.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	199,881,204.80	140,995,384.71
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	199,881,204.80	140,995,384.71
39200	Биет хөрөнгө	199,768,704.80	140,986,009.71
39203	Авто-тээврийн хэрэгсэл	99,394,890.00	127,590,890.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	45,392,043.79	85,712,013.12
39205	Машин, тоног төхөөрөмж (компьютер)	377,461,681.80	377,461,681.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	244,456,210.38	290,251,204.01
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29,899,956.60	34,390,856.60
39208	Хуримтлагдсан элэгдэл	17,139,569.43	22,494,201.56
39214	Бусад үндсэн хөрөнгө	4,568,164.00	4,568,164.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	4,568,164.00	4,568,164.00
39300	Биет бус хөрөнгө	112,500.00	9,375.00
39301	Програм хангамж	2,057,000.00	2,057,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	1,944,500.00	2,047,625.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	223,970,405.03	159,672,452.22
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	5,093,195.01	43,012.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,093,195.01	43,012.00
41300	Өглөг	5,093,195.01	43,012.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	43,012.00
41360	Бусад өглөг	5,093,195.01	0.00
41363	Татварын өр	4,712,026.61	0.00
41364	НДШ-ийн өглөг	381,168.40	0.00
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ, ӨМЧИЙН ДҮН	218,877,210.02	159,629,440.22
51	Засгийн газрын хувь оролцоо	264,349,638.94	264,349,638.94
51101	Засгийн газрын оруулсан капитал	264,349,638.94	264,349,638.94
51200	Хуримтлагдсан үр дүн	-45,472,826.92	-104,720,596.72
51210	Өмнөх үеийн үр дүн	-45,472,826.92	-45,472,826.92
51220	Тайлант үеийн үр дүн	0.00	-59,247,769.80

51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	398.00	398.00
VIII	НИЙТ ӨР ТӨЛБӨР ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	223,970,405.03	159,672,452.22

Аудитлагдсан Санхүүгийн үр дүнгийн тайлан

№	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
I	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1,038,307,566.57
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,038,307,566.57
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,029,848,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,029,848,800.00
1330	<u>Төсвийн захирагчдаас	0.00	8,458,766.57
133003	Хөрөнгийн	0.00	8,458,766.57
II	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	1,097,555,336.37
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	952,782,421.99
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1,076,043,917.37
21	<u>ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	0.00	952,782,421.99
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	0.00	862,299,394.99
210101	Үндсэн цалин	0.00	778,708,994.99
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	23,010,400.00
210104	Урамшуулал	0.00	60,580,000.00
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	90,483,027.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	90,483,027.00
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	24,614,000.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,214,000.00
210304	Байрны түрээс	0.00	23,400,000.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	0.00	13,521,896.00
210401	Бичиг хэрэг	0.00	1,750,600.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	4,848,870.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	0.00	611,606.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	417,900.00

210408	Бараа материал акталсны зардал	0.00	5,892,920.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	8,665,710.06
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	880,010.06
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	445,900.00
210604	Урсгал засвар	0.00	7,339,800.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	15,763,902.66
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	786,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	2,239,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	1,302,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	924,800.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	10,511,302.66
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	60,695,986.66
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	539,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	0.00	60,156,486.66
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	21,511,419.00
2133	<u>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.00	21,511,419.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	21,511,419.00
III	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	0.00	-59,247,769.80
VI	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	0.00	-59,247,769.80

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	<u>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	0.00	1,029,891,812.00
11	<u>ТАТВАРЫН ОРЛОГО	0.00	43,012.00
110	<u>Орлогын албан татвар	0.00	43,012.00
1100	<u>Хувь хүний орлогын албан татвар	0.00	43,012.00
110008	Шууд бус орлого	0.00	43,012.00
13	<u>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	0.00	1,029,848,800.00
1310	<u>Улсын төвлөрсөн төсвөөс	0.00	1,029,848,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	1,029,848,800.00
II	<u>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	0.00	1,029,891,812.00
21	<u>УРСГАЛ ЗАРДАЛ	0.00	957,875,617.00
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	0.00	1,008,380,393.00
21	<u>ЦАЛИН ХӨЛС,НЭМЭГДЭЛ,НДШ	0.00	957,875,617.00
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	0.00	867,392,590.00
210101	Үндсэн цалин	0.00	783,802,190.00

210102	Нэмэгдэл	0.00	0.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	23,010,400.00
210104	Урамшуулал	0.00	60,580,000.00
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	0.00	90,483,027.00
210201	Тэтгэврийн даатгал	0.00	90,483,027.00
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	0.00	24,614,000.00
210301	Гэрэл, цахилгаан	0.00	1,214,000.00
210304	Байрны түрээс	0.00	23,400,000.00
210305	Ашиглалтын зардалд төлсөн	0.00	0.00
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	0.00	7,988,976.00
210401	Бичиг хэрэг	0.00	2,074,600.00
210402	Тээвэр, шатахуун	0.00	4,848,870.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	0.00	611,606.00
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	36,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.00	417,900.00
210407	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд	0.00	0.00
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	8,559,500.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	670,200.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	0.00	445,900.00
210604	Урсгал засвар	0.00	7,443,400.00
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.00	8,691,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	750,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	2,239,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	1,139,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	0.00	163,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	500,000.00
210807	Газрын төлбөр	0.00	0.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0.00	0.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	0.00	3,900,000.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	650,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	0.00	650,500.00
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	21,511,419.00
2134	<u>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	0.00	21,511,419.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	21,511,419.00

АУДИТЛАГДСАН ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

(төгрөгөөр)

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2014 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	0.00	0.00
2015 оын 12 сарын 31-ээр үлдэгдэл	264,349,638.94	398.00	-45,472,826.92	218,877,210.02
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00	0.00	0.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00	0.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00	0.00
Тайлангийн үеийн үр дүн	0.00	0.00	-59,247,769.80	-59,247,769.80
2016 оын 12 сарын 31-р үлдэгдэл	264,349,638.94	398.00	-104,720,596.72	159,629,440.22

Аудитлагдсан Төсвийн гүйцэтгэлийн тайлан

№	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
I	<u>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,059,947,600.00	1,029,848,800.00	1,030,098,800.00	49.99
II	<U>НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	2,059,947,600.00	1,029,848,800.00	1,030,098,800.00	49.99
21	<U>УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	2,059,947,600.00	1,008,380,393.00	1,051,567,207.00	48.95
210	<u>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	97,629,000.00	50,504,776.00	47,124,224.00	51.73
2101	<u>Цалин хөлс болон нэмэгдэл суутгал	1,768,925,600.00	867,392,590.00	901,533,010.00	49.03
210101	Үндсэн цалин	1,597,816,800.00	783,802,190.00	814,014,610.00	49.05
210103	Унаа хоолны нэмэгдэл	49,948,800.00	23,010,400.00	26,938,400.00	46.07
210104	Урамшуулал	121,160,000.00	60,580,000.00	60,580,000.00	50.00
2102	<u>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	193,393,000.00	90,483,027.00	102,909,973.00	46.79
210201	Тэтгэврийн даатгал	193,393,000.00	90,483,027.00	102,909,973.00	46.79
2103	<u>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,300,000.00	24,614,000.00	20,686,000.00	54.34
210301	Гэрэл, цахилгаан	2,000,000.00	1,214,000.00	786,000.00	60.70
210304	Байрны түрээс	43,300,000.00	23,400,000.00	19,900,000.00	54.04
2104	<u>Хангамж, бараа материалын зардал	15,978,000.00	7,988,976.00	7,989,024.00	50.00
210401	Бичиг хэрэг	2,667,000.00	2,074,600.00	592,400.00	77.79
210402	Тээвэр, шатахуун	8,665,400.00	4,848,870.00	3,816,530.00	55.96
210403	Шуудан,холбоо, интернетийн төлбөр	2,175,400.00	611,606.00	1,563,794.00	28.11
210405	Хог,хаягдал зайлуулах,хортон мэрэгчдийн устгал,ариутгал	731,800.00	36,000.00	695,800.00	4.92
210406	БҮТЭЗүйлс	1,738,400.00	417,900.00	1,320,500.00	24.04
2106	<u>Эд хогшил, урсгал засварын зардал	17,556,600.00	8,559,500.00	8,997,100.00	48.75
210601	Багаж,техник хэрэгсэл	642,400.00	670,200.00	-27,800.00	104.33
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	2,168,200.00	445,900.00	1,722,300.00	20.57
210604	Урсгал засвар	14,746,000.00	7,443,400.00	7,302,600.00	50.48
2108	<u>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	17,642,400.00	8,691,800.00	8,950,600.00	49.27
210801	Бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,750,000.00	750,000.00	1,000,000.00	42.86
210802	Аудит баталгаажуулалт,зэрэглэл тогтоох	4,478,000.00	2,239,000.00	2,239,000.00	50.00
210803	Даатгалын үйлчилгээ	2,278,400.00	1,139,200.00	1,139,200.00	50.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	336,000.00	163,600.00	172,400.00	48.69
210806	Мэдээлэл,технологийн үйлчилгээ	1,000,000.00	500,000.00	500,000.00	50.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх,бэлтгэх	7,800,000.00	3,900,000.00	3,900,000.00	50.00
2109	<u>Бараа үйлчилгээний бусад зардал	1,152,000.00	650,500.00	501,500.00	56.47
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,152,000.00	650,500.00	501,500.00	56.47
213	<u>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.00	21,468,407.00	-21,468,407.00	
2134	<u>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас,санхүүжилт	0.00	21,468,407.00	-21,468,407.00	

213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	21,468,407.00	-21,468,407.00	
1	<i>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,016,760,786.00	1,029,848,800.00	986,911,986.00	51.06
1200041	<i>ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	2,016,760,786.00	1,029,848,800.00	986,911,986.00	51.06
13	<i>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,016,760,786.00	1,029,848,800.00	986,911,986.00	51.06
131001	Улсын төсвөөс санхүүжих	2,016,760,786.00	1,029,848,800.00	986,911,986.00	51.06
3101	<i>МӨНГӨН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ	-43,186,814.00	0.00	-43,186,814.00	0.00
9001	Удирдах ажилтан	3.00	3.00	0.00	100.00
9002	Гүйцэтгэх ажилтан	63.00	63.00	0.00	100.00
9003	Үйлчилгээний ажилтан	8.00	9.00	-1.00	112.50